


## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 6,876.3 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 6,326.5 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 549.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 138.9 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны алдагдал төлөвлөсөн дүнгээс 1,647.4 тэрбум төгрөгөөр буурч сайжирсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2019 оны эхний 8 сарын байдлаар нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 185.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 117.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 41.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол орон нутгийн төсвийн орлого 44.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу биелсэн байна.

2019 оны эхний 8 сарын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 18.2 хувь буюу 1,059.2 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 17.0 хувь буюу 920.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бөгөөд төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 1.2 пунктээр өндөр байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 138.9 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

### Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

#### Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,106.7	-567.2	-1,252.4	220.8	-685.2
Засгийн газрын бонд	-2,138.5	406.6	-140.6	-34.6	-547.2
Засгийн газрын зээл	511.6	1,024.5	793.0	77.4	-231.5
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	100.0	50.0	50.0	100.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	148.9	0.0	0.0	-148.9
Өмч хувьчлал	9.4	34.8	0.3	0.8	-34.5
<b>НИЙТ ДҮН</b>	<b>-410.8</b>	<b>1,097.6</b>	<b>-549.7</b>	<b>-50.1</b>	<b>-1,647.4</b>

Эх сурвалж: Сангийн яам

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 224.0 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 140.6 тэрбум төгрөг төлж, 550.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, мөн 272.1 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

## 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

*Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,876.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18.2 хувь буюу 1,059.2 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 5.8 хувь буюу 376.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.*

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 3.8 хувь буюу 185.1 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 8.1 хувь буюу 117.2 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 15.3 хувь буюу 41.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол Орон нутгийн төсөв 2.4 хувь буюу 44.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 17.5 хувь буюу 752.3 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 5.7 хувь буюу 98.9 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 18.2 хувь буюу 239.4 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 24.4 хувь буюу 61.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар  
**Хүснэгт 2.**

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	<b>5,790.4</b>	<b>5,860.3</b>	<b>1,866.2</b>	<b>1,821.5</b>	<b>1,438.0</b>	<b>1,555.2</b>	<b>270.5</b>	<b>311.9</b>
ИРЭЭДҮЙН ӨВ САН	778.9	770.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	148.9	42.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	<b>4,862.6</b>	<b>5,047.7</b>	<b>1,866.2</b>	<b>1,821.5</b>	<b>1,438.0</b>	<b>1,555.2</b>	<b>270.5</b>	<b>311.9</b>
<b>Татварын орлого</b>	3,932.0	4,214.8	789.5	774.7	1,034.4	1,151.5	270.5	311.9
Орлогын албан татвар	961.6	1,124.5	547.5	531.6	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,034.4	1,151.5	270.5	311.9
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	103.7	102.1	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,439.2	1,523.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	592.4	584.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	11.2	10.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	503.5	513.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	424.2	458.1	138.3	141.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	930.6	832.9	1,076.7	1,046.8	403.7	403.7	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	453.6	481.2	124.3	109.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.7	0.5	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	267.1	182.9	8.7	1.3	403.7	403.7	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	209.9	168.7	943.1	935.8	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.9 хувийг татварын орлого, 9.1 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 21.5 хувь буюу 1,104.8 тэрбум төгрөгөөр өссөн бол татварын бус орлого 6.8 хувь буюу 45.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**Татварын орлого 6,248.9 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 7.5 хувь буюу 435.5 тэрбум төгрөгөөр давж биелжээ.**

Татварын орлогын 26.5 хувийг орлогын албан татвар, 20.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.6 хувийг хөрөнгийн албан татвар, 24.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.4 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.6 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3.** Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд хөрөнгийн албан татвар, тусгай зориулалтын орлого болон онцгой албан татвараас бусад төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Үүнд: орлогын албан татвар 9.7 хувь /147.0 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 15.3 хувь /167.5 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 5.9 хувь /84.5 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 2.0 хувь /9.8 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр хураамж 6.5 хувь /36.6 тэрбум.төг/- иар тус тус давж биелсэн байна. Харин хөрөнгийн албан татвар 1.5 хувь /1.6 тэрбум.төг/, онцгой албан татвар 1.4 хувь /8.0 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 2.7 хувь /0.3 тэрбум.төг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 1.7 хувь /1.1 тэрбум.төг/, бууны албан татвар 16.5 хувь /0.1 тэрбум.төг/, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 0.9 хувь /0.3 тэрбум.төг/, дотоодын архи, дарсны онцгой албан татвар 11.8 хувь /15.5 тэрбум.төг/,

автобензин, дизелийн түлшний албан татвар 2.7 хувь /0.3 тэрбум.төг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ.

*Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 38.5 хувийг нийгмийн даатгалын орлого, 33.7 хувийг орлогын албан татвар, 19.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.4 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 2.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого эзэлсэн бол хөрөнгийн албан татвар тус бүр 0.4 хувь, онцгой албан татвар 1.8 хувь, тусгай зориулалтын орлого 0.1 хувийн бууралттайгаар тус тус нөлөөлжээ.*


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр татварын орлого 1,104.8 тэрбум төгрөг буюу 21.5 хувиар өсөхөд орлогын албан татвар 362.9 тэрбум (28.1%), нийгмийн даатгалын орлого 267.1 тэрбум (26.9%), хөрөнгийн албан татвар 10.9 тэрбум (11.9%), нэмэгдсэн өртгийн албан татвар 174.9 тэрбум (13.0%), онцгой албан татвар 89.3 тэрбум (18.0%), тусгай зориулалтын орлого 2.5 тэрбум (30.4%), гадаад үйл ажиллагааны орлого 80.7 тэрбум (18.7%), бусад татвар, төлбөр, хураамж 116.4 тэрбум (24.1%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

*Татварын орлогын өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, нийт өсөлтийн 32.9 хувийг орлогын албан татвар, 24.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 15.8 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 10.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 8.1 хувийг онцгой албан татвар, 7.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.0 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого тус тус эзэлжээ.*

*Татварын бус орлого 627.3 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 6.8 хувь буюу 45.6 тэрбум төгрөгөөр буурч, төлөвлөснөөс 59.3 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар дутуу төвлөрсөн байна.*

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд гадаад хандив тусламжийн орлого 71.7 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 24.1 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 11.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин торгуулийн орлого 13.4 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 18.3 тэрбум, түрээсийн орлого 0.2 тэрбум, бусад орлого 16.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Татварын бус орлогын 94.1 хувийг нийтлэг татварын бус орлого, 5.8 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 29.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 24.7 хувийг газрын тосны орлого, 16.5 хувийг навигагийн орлого, 11.1 хувийг бусад орлого, 7.6 хувийг торгуулийн орлого, 4.4 хувийг хүүгийн орлого, 0.4 хувийг хувьцааны ногдол ашиг, түрээсийн орлого 0.2 хувийг тус тус эзэлж байна.

*Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 8 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 10 нь 0.8-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 4.6 хувь, Гаалийн ерөнхий газар 2.0 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.*

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

## Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2019 оны эхний 08 сарын гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Сангийн сайд</b>	<b>4,216,040.3</b>	<b>5,078,707.8</b>	<b>5,140,653.9</b>	<b>-61,946.1</b>	<b>101.2</b>
Татварын ерөнхий газар	2,399,522.4	2,818,331.7	2,948,224.2	-	104.6
Үүнээс: Тогтворжуулалтын санд	173,049.6	148,916.3	42,106.9	106,809.3	28.3
Ирээдүйн өв санд	443,028.9	598,870.2	619,517.9	-20,647.7	103.4
Гаалийн ерөнхий газар	1,734,566.8	2,041,460.1	2,082,924.5	-41,464.5	102.0
Сангийн яам	38,782.2	33,259.4	48,690.6	-15,431.1	146.4
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	37,559.8	78,764.2	21,228.0	57,536.1	27.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,576.7	102,920.2	35,175.0	67,745.2	34.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,032.3	3,972.3	4,411.6	-439.3	111.1
<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>0.0</b>	<b>66.7</b>	<b>0.0</b>	<b>66.7</b>	<b>0.0</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	66.7	0.0	66.7	0.0
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>14,373.5</b>	<b>372,954.3</b>	<b>5,810.1</b>	<b>367,144.2</b>	<b>1.6</b>
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	1,000.0	1,550.0	886.6	663.4	57.2
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	10,408.8	369,000.0	2,331.3	366,668.7	0.6
Үүнээс: Ирээдүйн өв санд	0.0	180,000.0	150,908.9	29,091.1	83.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,964.7	2,404.3	2,592.2	-187.9	107.8
<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>10,075.1</b>	<b>6,138.5</b>	<b>8,494.8</b>	<b>-2,356.2</b>	<b>138.4</b>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,389.0	2,400.0	2,547.6	-147.6	106.2
Стандарт, хэмжил зүйн газар	1,815.6	2,254.0	2,050.0	204.0	90.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,870.5	1,484.5	3,897.1	-2,412.6	262.5
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>32,712.6</b>	<b>32,044.4</b>	<b>31,388.8</b>	<b>655.6</b>	<b>98.0</b>
Улсын бүртгэлийн ерөнхий газар	12,557.9	13,200.0	10,819.5	2,380.5	82.0
Цагдаагийн ерөнхий газар	926.6	2,066.6	1,042.5	1,024.2	50.4
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	3,520.6	5,479.2	4,867.5	611.7	88.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,707.5	11,298.6	14,659.3	-3,360.8	129.7
<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>17,375.1</b>	<b>12,498.8</b>	<b>16,722.1</b>	<b>-4,223.4</b>	<b>133.8</b>
Дипломат төлөөлөгчийн газрууд	16,999.2	11,465.4	15,797.0	-4,331.6	137.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	375.9	1,033.3	925.1	108.2	89.5
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>113,228.1</b>	<b>105,163.3</b>	<b>108,703.5</b>	<b>-3,540.2</b>	<b>103.4</b>

Иргэний нисэхийн ерөнхий газар	107,675.0	103,600.0	103,600.0	0.0	100.0
Зам, тээврийн хөгжлийн яам	132.3	130.0	130.0	0.0	100.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,420.8	1,433.3	4,973.5	-3,540.2	347.0
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>185,644.0</b>	<b>200,065.1</b>	<b>198,545.1</b>	<b>1,520.0</b>	<b>99.2</b>
Ашигт малтмал, газрын тосны газар	184,792.7	198,312.9	197,012.0	1,301.0	99.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	851.4	1,752.2	1,533.1	219.0	87.5
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>24,090.1</b>	<b>46,013.1</b>	<b>52,300.5</b>	<b>-6,287.4</b>	<b>113.7</b>
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	275.0	386.6	290.0	96.6	75.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	318.7	420.7	351.9	68.9	83.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	23,496.5	45,205.8	51,658.6	-6,452.9	114.3
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>127,545.3</b>	<b>172,521.5</b>	<b>53,227.4</b>	<b>119,294.1</b>	<b>30.9</b>
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	85,349.5	147,257.7	28,350.0	118,907.8	19.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	42,195.7	25,263.8	24,877.4	386.4	98.5
<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>149,263.4</b>	<b>169,783.2</b>	<b>157,018.9</b>	<b>12,764.3</b>	<b>92.5</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	131,023.6	150,871.9	137,363.7	13,508.2	91.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	18,239.8	18,911.2	19,655.2	-743.9	103.9
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>	<b>730.5</b>	<b>211.7</b>	<b>814.3</b>	<b>-602.6</b>	<b>384.7</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	730.5	211.7	814.3	-602.6	384.7
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>112.5</b>	<b>116.8</b>	<b>121.9</b>	<b>-5.1</b>	<b>104.3</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	112.5	116.8	121.9	-5.1	104.3
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b>	<b>15,358.4</b>	<b>5,567.7</b>	<b>4,234.0</b>	<b>1,333.7</b>	<b>76.0</b>
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	11,506.7	2,000.0	0.0	2,000.0	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,851.7	3,567.7	4,234.0	-666.3	118.7
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>815.0</b>	<b>1,203.2</b>	<b>790.0</b>	<b>413.2</b>	<b>65.7</b>
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	815.0	1,203.2	790.0	413.2	65.7
<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>30,862.1</b>	<b>32,110.8</b>	<b>16,912.7</b>	<b>15,198.1</b>	<b>52.7</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,237.4	5,024.5	4,702.8	321.7	93.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	26,624.7	27,086.3	12,209.9	14,876.4	45.1
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>166.3</b>	<b>40.0</b>	<b>38.9</b>	<b>1.1</b>	<b>97.2</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	166.3	40.0	38.9	1.1	97.2
<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>	<b>577.3</b>	<b>622.0</b>	<b>622.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	577.3	622.0	622.0	0.0	100.0

Эх сурвалж: Сангийн яам

### 3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 7,597.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 83.3 хувийг ашиглаж 1,271.2 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 920.3 тэрбум төгрөг буюу 17.0 хувиар өсч 6,326.5 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/  
Хүснэгт 4. /тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.



НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,760.5	4,983.0	2,130.0	1,638.2	1,373.9	1,353.6	270.6	211.7
НИЙТ ЗАРЛАГА	5,661.6	4,852.5	2,104.4	1,634.4	1,373.9	1,353.6	270.6	211.7
УРСГАЛ ЗАРДАЛ	4,437.8	3,954.6	1,651.3	1,405.9	1,373.9	1,353.6	270.6	211.7
Бараа, ажил, үйлчилгээний зардал	1,710.0	1,408.4	1,287.6	1,108.8	16.6	14.9	3.7	2.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	543.2	521.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	514.8	445.9	107.0	93.1	0.0	0.0	32.7	22.2
Урсгал шилжүүлэг	1,669.8	1,579.0	256.8	204.0	1,357.3	1,338.7	234.2	187.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,223.8	897.9	453.1	228.5	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98.9	130.5	25.6	3.8	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-897.9	64.7	-263.8	183.3	64.1	201.6	0.0	100.2

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 777.5 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 491.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 20.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 58.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 732.0 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 102.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 164.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 13.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 17.0 хувь буюу 738.9 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 71.7 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 504.3 тэрбум, хөрөнгийн зардал 306.3 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

*Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 118.2 тэрбум төгрөг буюу 18.5 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 21.9 тэрбум төгрөгөөр буюу 4.0 хувиар тус тус буурсан байна.*

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл  
/зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,406.2</b>	<b>7,597.7</b>	<b>6,326.5</b>	<b>83.3</b>	<b>1,271.2</b>
НИЙТ ЗАРЛАГА	5,199.7	7,473.2	6,192.2	82.9	1,281.0
УРСГАЛ ЗАРДАЛ	4,533.7	5,796.3	5,065.8	87.4	730.5
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,961.8</b>	<b>2,860.9</b>	<b>2,386.2</b>	<b>83.4</b>	<b>474.7</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,182.4	1,514.4	1,450.3	95.8	64.2
Үндсэн цалин	886.6	1,077.3	1,066.4	99.0	10.8
Нэмэгдэл	211.4	317.2	279.3	88.0	38.0
Унаа хоолны хөнгөлөлт	27.6	39.1	34.7	88.7	4.4
Урамшуулал	35.0	61.9	52.1	84.2	9.8
Гэрээт ажлын хөлс	21.8	19.0	17.8	93.6	1.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэврийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэмжийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
ҮОМШӨ-ний даатгал	0.0	0.0	0.0	-	0.0

Ажилгүйдлийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Эрүүл мэндийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136.6</b>	<b>170.0</b>	<b>147.4</b>	<b>86.7</b>	<b>22.5</b>
Гэрэл, цахилгаан	28.4	34.6	30.3	87.5	4.3
Түлш, халаалт	82.6	101.5	89.1	87.8	12.4
Цэвэр, бохир ус	13.4	18.1	14.0	77.6	4.0
Байрны түрээс	12.1	15.8	14.0	88.8	1.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>73.6</b>	<b>97.4</b>	<b>81.7</b>	<b>83.9</b>	<b>15.7</b>
Бичиг хэрэг	6.3	8.8	7.5	84.5	1.4
Тээвэр, шатахуун	28.0	37.5	30.4	81.2	7.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.9	9.6	7.5	78.5	2.1
Ном, хэвлэл	1.6	1.9	1.1	57.1	0.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24.7	31.5	28.5	90.6	3.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6.1	8.2	6.7	82.4	1.4
<b>Нормативт зардал</b>	<b>161.5</b>	<b>208.6</b>	<b>168.7</b>	<b>0.0</b>	<b>39.9</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84.8	107.0	89.9	84.1	17.0
Хоол, хүнс	55.9	72.7	57.7	79.3	15.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20.9	28.8	21.0	72.9	7.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36.5</b>	<b>65.6</b>	<b>45.2</b>	<b>68.9</b>	<b>20.4</b>
Багаж, техник, хэрэгсэл	10.7	20.9	14.6	69.9	6.3
Тавилга	1.5	5.1	2.7	53.7	2.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.9	1.2	0.5	42.4	0.7
Урсгал засвар	23.4	38.4	27.4	71.1	11.1
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14.9</b>	<b>26.3</b>	<b>18.4</b>	<b>70.2</b>	<b>7.8</b>
Гадаад албан томилолт	6.0	8.7	6.5	74.6	2.2
Дотоод албан томилолт	6.9	13.6	8.5	62.3	5.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	2.0	4.0	3.5	87.8	0.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>202.0</b>	<b>479.8</b>	<b>282.0</b>	<b>58.8</b>	<b>197.8</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184.1	446.8	259.4	58.1	187.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.8	1.7	1.0	58.5	0.7
Даатгалын үйлчилгээ	7.4	8.7	8.1	92.8	0.6
Тээврийн хэрэгслийн татвар	0.4	0.7	0.4	61.9	0.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.2	0.2	0.2	63.7	0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4.5	10.8	5.6	52.3	5.2
Газрын төлбөр	0.5	1.1	0.6	53.5	0.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.7	2.4	1.0	40.5	1.4
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3.5	7.3	5.7	77.7	1.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>154.1</b>	<b>298.9</b>	<b>192.5</b>	<b>64.4</b>	<b>106.4</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	134.8	271.0	173.3	63.9	97.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19.3	27.9	19.2	68.9	8.7
<b>ХҮҮ</b>	<b>639.5</b>	<b>543.2</b>	<b>521.3</b>	<b>96.0</b>	<b>21.9</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	359.9	382.7	382.0	99.8	0.8
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	279.5	160.5	139.3	86.8	21.2
<b>ТАТААС</b>	<b>140.5</b>	<b>250.7</b>	<b>157.6</b>	<b>62.8</b>	<b>93.2</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	20.9	52.5	43.6	83.1	8.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	119.6	198.2	113.9	57.5	84.3
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,792.0</b>	<b>2,141.4</b>	<b>2,000.7</b>	<b>93.4</b>	<b>140.7</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>45.7</b>	<b>82.5</b>	<b>46.9</b>	<b>56.8</b>	<b>35.6</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	41.9	74.4	42.2	56.7	32.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3.8	8.1	4.7	58.0	3.4
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,746.2</b>	<b>2,058.9</b>	<b>1,953.8</b>	<b>94.9</b>	<b>105.1</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,177.6	1,356.4	1,338.2	98.7	18.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	391.6	471.5	446.9	94.8	24.6



Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3.3	3.8	2.6	69.2	1.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100.5	110.1	72.2	65.6	37.9
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	3.9	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42.0	74.7	61.5	82.2	13.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27.3	32.6	26.1	80.1	6.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3.9	9.9	6.4	65.0	3.5
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>666.0</b>	<b>1,676.9</b>	<b>1,126.4</b>	<b>67.2</b>	<b>550.5</b>
Барилга байгууламж	309.8	1,096.3	826.1	75.4	270.2
Их засвар	30.7	91.3	60.5	66.2	30.8
Тоног төхөөрөмж	123.2	146.1	52.6	36.0	93.5
Бусад хөрөнгө	199.3	328.9	176.8	53.8	152.1
Стратегийн нөөц хөрөнгө	3.0	14.3	10.4	72.6	3.9
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	-	0.0
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>206.5</b>	<b>124.5</b>	<b>134.3</b>	<b>107.9</b>	<b>-9.8</b>
Эргэж төлөгдөх зээл	156.8	19.2	80.4	419.9	-61.3
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	-	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	49.7	105.3	53.9	51.2	51.4

Эх сурвалж: Сангийн Яам

**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 80.1 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.8 пунктээр буурсан байна.**


Нэгдсэн төсвийн нийт зарлагын 80.1 хувь буюу 5,065.8 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 47.1 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 39.5 хувийг урсгал шилжүүлэг, 10.3 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.1 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 532.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 118.2 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 424.4 тэрбум, урсгал шилжүүлэг 208.8 тэрбум, татаас 17.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан улсын төсвийн нийт зарлагын төсөв 777.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.**

Улсын төсвийн нийт зарлагын 26.5 хувийг Сангийн сайдын багц, 20.3 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 18.7 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 9.4 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 7.0 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 3.4 хувийг Монгол Улсын Ерөнхий сайдын багц, 2.9 хувийг

**График 5.** Урсгал зардлын бүтэц /хувиар/



Батлан хамгаалахын сайдын багц, 1.6 хувийг Монгол Улсын шадар сайдын багц, үлдэх 10.1 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

**Хүснэгт 6.**

*/сая төгрөг/*

Төсвийн ерөнхийлөн захирагч	2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	3,292.7	2,857.5	435.1	86.8
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	29,267.8	27,299.9	1,968.0	93.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	253,998.9	171,041.5	82,957.4	67.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	27,282.3	19,648.6	7,633.7	72.0
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	52,231.0	46,839.6	5,391.4	89.7
САНГИЙН САЙД	1,676,018.4	1,321,269.4	354,749.0	78.8
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	177,338.2	146,502.1	30,836.2	82.6
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	512,622.5	466,961.3	45,661.2	91.1
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,984.1	1,852.2	131.9	93.4
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	5,448.2	3,958.8	1,489.4	72.7
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	34,814.8	32,043.2	2,771.7	92.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	23,135.1	20,843.8	2,291.3	90.1
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	3,002.4	2,795.1	207.3	93.1
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	10,301.8	8,399.4	1,902.4	81.5
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	7,403.3	6,132.7	1,270.6	82.8
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,677.2	2,256.9	420.3	84.3
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1,008.9	746.1	262.8	74.0
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	3,947.3	3,500.0	447.3	88.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	96,062.2	81,378.2	14,684.0	84.7
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	819.5	645.9	173.6	78.8
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	749.8	654.2	95.5	87.3
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	12,256.4	8,797.8	3,458.5	71.8
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	113,454.5	62,255.3	51,199.3	54.9
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	374,115.0	348,499.7	25,615.3	93.2
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	61,605.5	52,747.8	8,857.7	85.6
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	973,735.0	930,560.4	43,174.5	95.6
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	81,735.8	78,894.0	2,841.8	96.5
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	23,648.6	16,179.0	7,469.5	68.4
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	54,436.9	41,739.5	12,697.4	76.7
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	65,528.7	63,877.6	1,651.1	97.5
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	1,076,573.9	1,011,815.5	64,758.4	94.0
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>5,760,496.4</b>	<b>4,982,993.0</b>	<b>777,503.5</b>	<b>86.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

#### 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2019 онд нийт 1,553.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. 2019 оны эхний 8 сарын байдлаар 439.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 417.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**График 6.** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 оны эхний 8 сарын байдлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 439.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс 417.6 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 22.3 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар дутуу зарцуулагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

**Хүснэгт 7.**

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	2019 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төсөв	Гүйц	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	2,000.0	1,523.2	1,523.2	0.0	100.0
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	14,231.2	3,004.4	3,004.4	0.0	0.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	6,363.6	1,863.7	1,863.7	0.0	100.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	38,714.0	9,026.1	8,355.2	671.0	92.6
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	13,776.2	756.9	596.9	160.0	0.0
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	2,875.0	2,374.8	2,374.8	0.0	100.0
САНГИЙН САЙД	134,386.3	17,906.8	15,703.9	2,202.9	87.7
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	42,883.4	22,670.2	21,282.3	1,387.9	93.9
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	33,895.4	8,597.2	7,499.9	1,097.2	87.2
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	15,499.7	7,004.1	6,908.1	96.0	0.0
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	141,350.1	45,128.4	42,709.7	2,418.7	94.6
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	616,453.7	156,874.7	153,675.7	3,199.0	98.0
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	241,781.9	75,258.4	74,715.1	543.2	99.3
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	2,000.0	0.0	0.0	0.0	0.0
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	29,533.0	2,779.4	2,779.4	0.0	100.0
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	97,150.3	50,976.0	49,464.7	1,511.3	97.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	104,237.9	26,979.5	18,495.4	8,484.1	68.6
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	820.0	737.7	737.7	0.0	0.0
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	247.0	246.6	246.6	0.0	0.0
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	500.0	500.0	479.8	20.2	0.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4,400.4	3,740.9	3,548.9	192.1	0.0
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,000.0	1,258.9	1,258.9	0.0	0.0
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,500.0	500.0	185.5	314.5	0.0
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	800.0	219.2	219.2	0.0	0.0
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	4,000.0	0.0	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,553,399.1</b>	<b>439,927.0</b>	<b>417,628.9</b>	<b>22,298.1</b>	<b>94.9</b>

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 2019 оны эхний 8 сарын байдлаар 133.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 88.1 тэрбум төгрөг зарцуулж 66.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2019 оны эхний 8 сарын санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчдаар/

**Хүснэгт 8.**


/сая төгрөг/

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР, ХҮЧИН ЧАДАЛ, БАЙРШИЛ	ТӨСӨВ	2019 оны 8 дугаар сарын гүйцэтгэл		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>	<b>144,699.2</b>	<b>133,446.4</b>	<b>88,055.3</b>	<b>45,391.1</b>	<b>66.0</b>
<b>Үндэсний хөгжлийн газар</b>	<b>144,699.2</b>	<b>133,446.4</b>	<b>88,055.3</b>	<b>45,391.1</b>	<b>66.0</b>
<i>Концессын төслийн эргэн төлөлт</i>	<i>144,699.2</i>	<i>133,446.4</i>	<i>88,055.3</i>	<i>45,391.1</i>	<i>66.0</i>
<b>I.Хөрөнгө оруулалт</b>	<b>144,699.2</b>	<b>133,446.4</b>	<b>88,055.3</b>	<b>45,391.1</b>	<b>66.0</b>
<b>Шилжих</b>	<b>144,699.2</b>	<b>133,446.4</b>	<b>88,055.3</b>	<b>45,391.1</b>	<b>66.0</b>
Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам төсөл	28,017.9	28,017.9	28,017.9	0.0	100.0
Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл	42,225.4	42,225.4	42,225.4	0.0	100.0
Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	9,075.6	9,075.6	9,075.6	0.0	100.0
Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/	3,197.0	3,016.3	3,014.2	2.1	99.9
"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт /Говь-сүмбэр/	37,150.5	35,001.4	0.0	35,001.4	0.0
Сургуулийн барилга, 320 суудал / Хөвсгөл, Цагаан-Уул сум/	6,116.4	0.00	0.00	0.0	0.0
Цэцэрлэгийн барилга, 150 ор / Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2,806.6	0.00	0.00	0.0	0.0
Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, 1 дүгээр цэцэрлэг/	2,105.7	2,105.7	2,105.7	0.0	100.0
Соёл, спортын цогцолборын барилга, 500 суудал /Хөвсгөл, Тариалан сум/	3,616.5	3,616.5	3,616.5	0.0	100.0
Идэрийн голын хөвдөг гүүр /Хөвсгөл, Галт сум/	787.5	787.5	0.0	787.5	0.0
Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22,2 км хатуу хучилттай авто зам	2,600.0	2,600.0	0.0	2,600.0	0.0
Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ, дэд станц	7,000.0	7,000.0	0.0	7,000.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>144,699.2</b>	<b>133,446.4</b>	<b>88,055.3</b>	<b>45,391.1</b>	<b>66.0</b>

Эх сурвалж: Сангийн яам

**5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сан**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санд 311.9 тэрбум төгрөг төвлөрсөн нь 61.1 тэрбум төгрөг буюу 24.4 хувиар, нийгмийн даатгалын санд 1,555.2 тэрбум төгрөг төвлөрсөн нь 239.4 тэрбум төгрөг буюу 18.2 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Тус 2 санд нийт 1,867.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 300.5 тэрбум төгрөг буюу 19.2 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

**Нийгмийн даатгалын сангийн орлого:****График 7.** Нийгмийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/


2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 1,555.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 8.1 хувь буюу 117.2 тэрбум төгрөгөөр давж биелэн орлогын гүйцэтгэл 108.1 хувьтай гарчээ.

Тайлант хугацаанд ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын санд нийт 1,151.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, мөн тус санд улсын төсвөөс 403.7 тэрбум төгрөгийн татаас олгосон байна. Нийгмийн даатгалын


шимтгэлийн орлогыг сангийн төрлөөр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын санд 866.0 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 109.0 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 146.7 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 29.8 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:**

Эрүүл мэндийн даатгалын санд 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 311.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 15.3 хувь буюу 41.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба орлогын гүйцэтгэл 115.3 хувьтай гарчээ.

**График 8.** Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн зарлага:**

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага 211.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 1,353.6 тэрбум, нийт 1,565.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 178.0 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар өссөн байна. Үүнд: тэтгэврийн даатгалын сангийн зарлага 156.2 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8.9 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 66.6 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 43.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

**Нийгмийн даатгалын сангийн зарлага:****График 9.** Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/


2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр тус сангийн нийт зарлага 1,353.6 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 20.3 тэрбум төгрөг буюу 1.5 хувиар дутуу зарцуулагдсан байна.

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны,




тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн болон бусад зардалд нийт 1,221.8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 83.1 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 98.0 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж болон бусад зардалд 64.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**График 10.** Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын бүтэц



**Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:**

**График 11.** Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/



2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 270.6 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 211.7 тэрбум төгрөгийг зарцуулснаар тус сангийн гүйцэтгэл 78.2 хувьтай гарчээ. Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 13.3 тэрбум төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн зарцуулалттай гарчээ.

**6. Орон нутгийн төсөв**


**2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 491.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.**

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 1,821.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 2.4 хувь буюу 44.7 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө дутуу биелсэн байна. Орон нутгийн төсвийн нийт зарлага 1,638.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 23.1 хувь буюу 491.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 183.3 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 5.7 хувиар буюу 98.9 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 6.7 хувь буюу 102.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 48.6 хувийг орон нутгийн төсвийн орлого, 40.5 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 6.3 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 4.5 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 115.4 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

**График 12.** Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/





Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

## Хүснэгт 9.

/сая төгрөг/

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	7,500.6	7,500.6	100.0	26,218.3	26,218.3	100.0	3,550.7	3,334.8	93.9
Баян-Өлгий	4,125.7	4,125.7	100.0	34,146.7	34,146.7	100.0	4,606.6	4,307.7	93.5
Баянхонгор	11,615.8	11,615.8	100.0	26,250.5	26,250.5	100.0	4,110.5	3,707.4	90.2
Булган	1,041.7	1,041.7	100.0	19,004.6	19,004.6	100.0	2,258.8	2,123.4	94.0
Говьсүмбэр	901.3	901.3	100.0	4,900.2	4,900.2	100.0	608.0	570.0	93.7
Говь-Алтай	9,511.4	9,511.4	100.0	21,136.0	21,136.0	100.0	3,806.9	3,555.5	93.4
Дархан-Уул	0.0	0.0	-	21,593.7	21,593.7	100.0	3,059.9	2,878.8	94.1
Дорноговь	0.0	0.0	-	20,253.8	20,253.8	100.0	4,071.5	3,456.0	84.9
Дорнод	0.0	0.0	-	20,954.2	20,954.2	100.0	3,858.2	3,546.8	91.9
Дундговь	6,962.0	6,962.0	100.0	15,048.1	15,048.1	100.0	2,251.9	2,006.2	89.1
Завхан	9,498.5	9,498.5	100.0	23,581.5	23,581.5	100.0	3,349.6	3,104.2	92.7
Орхон	0.0	0.0	-	23,698.1	23,698.1	100.0	3,225.3	3,027.3	93.9
Өвөрхангай	10,491.6	10,491.6	100.0	29,746.4	29,746.4	100.0	4,377.2	4,122.1	94.2
Өмнөговь	0.0	0.0	-	18,096.0	18,096.0	100.0	3,919.6	3,422.5	87.3
Сүхбаатар	6,190.1	6,190.1	100.0	17,796.6	17,796.6	100.0	3,244.5	2,734.5	84.3
Сэлэнгэ	3,648.4	3,648.4	100.0	29,707.1	29,707.1	100.0	3,789.5	3,568.4	94.2
Төв	4,344.9	4,344.9	100.0	27,105.2	27,105.2	100.0	3,259.8	3,060.0	93.9
Увс	14,653.7	14,653.7	100.0	26,541.9	26,541.9	100.0	4,075.2	3,809.9	93.5
Улаанбаатар	0.0	0.0	-	247,853.6	247,853.6	100.0	15,661.5	14,430.5	92.1
Ховд	5,964.1	5,964.1	100.0	25,540.4	25,540.4	100.0	4,165.5	3,852.3	92.5
Хөвсгөл	12,116.2	12,116.2	100.0	35,643.4	35,643.4	100.0	5,490.8	5,150.5	93.8
Хэнтий	6,854.2	6,854.2	100.0	22,872.3	22,872.3	100.0	3,210.6	2,963.0	92.3
<b>ДҮН</b>	<b>115,420.3</b>	<b>115,420.3</b>	<b>100.0</b>	<b>737,688.6</b>	<b>737,688.6</b>	<b>100.0</b>	<b>89,952.1</b>	<b>82,731.8</b>	<b>92.0</b>

Эх сурвалж: Сангийн Яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 737.7 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгосон байна.

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 82.7 тэрбум төгрөгийг шилжүүлж, аймаг орон нутагт хуваарилсан нь төлөвлөсөн хэмжээний 92.0 хувьд хүрч биелжээ.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал Говьсүмбэр аймаг 1,019.6 сая, Орхон аймаг 7,601.5 сая, Өвөрхангай аймаг 185.6 сая, Төв аймаг 683.2 сая, Хөвсгөл аймаг 98.9 сая, Хэнтий аймаг 1,197.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн бол Архангай аймаг 1,448.8 сая, Баян-Өлгий аймаг 3,781.5 сая, Баянхонгор аймаг 189.8 сая, Булган аймаг 1,030.0 сая, Говь-Алтай аймаг 12.0 сая, Дархан-Уул аймаг 457.7 сая, Дорноговь аймаг 1,580.6 сая, Дорнод аймаг 1,365.7 сая, Дундговь аймаг 77.5 сая, Завхан аймаг 499.6 сая, Өмнөговь аймаг 19,760.2 сая, Сүхбаатар аймаг 229.0 сая, Сэлэнгэ аймаг 1,627.2 сая, Увс аймаг 139.1 сая, Улаанбаатар хот 23,627.0 сая, Ховд аймаг 170.7 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрчээ.

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 44.7 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар дутуу биелэхэд орон нутгийн орлого 4.1 хувь буюу 37.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 8.0 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

## ДУГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

**Төсвийн орлогын хувьд:** 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6,876.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 376.2 тэрбум төгрөгөөр давж биелэн, өмнөх оны мөн үеэс 1,059.2 тэрбум төгрөгийн өсөлттэй байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 2019 оны эхний 8 сард 5.8 хувиар давж биелэн, гүйцэтгэл 105.8 хувийн биелэлттэй байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс өсөлттэй гарч, 18.2 хувиар буюу 1,059.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт нөлөөлсөн. Татварын орлого 2019 оны эхний 8 сарын байдлаар 7.5 хувиар буюу 435.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелжээ. Татварын орлогын хувьд хөрөнгийн албан татвар, тусгай зориулалтын орлого болон онцгой албан татвараас бусад төрлийн татварын орлого төлөвлөснөөс давж биелсэн байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2019 оны эхний 8 сард 91.4 хувийн биелэлттэй гарч, тус орлого 59.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь тусламжийн орлого 71.7 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 24.1 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 11.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу буюу төлөвлөсөнд хүрч биелээгүйтэй холбоотой байна.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2019 оны эхний 8 сарын байдлаар 1,271.2 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 83.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл төлөвлөгөөтэй харьцуулахад эхний 8 сард 16.7 хувиар дутуу зарцуулагдсан байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ эхний 8 сарын байдлаар 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, 417.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогджээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс 118.2 тэрбум төгрөгөөр буюу 18.5 хувиар буурч, төлөвлөснөөс 21.9 тэрбум төгрөгөөр буюу 4.0 хувиар бага зарцуулалттай гарсан байна.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА